



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 1/37

Мандалговь

Г Дэмжлэг үзүүлэх тухай 7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.12, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 8 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэлгэрхангай сумын уугуул Монгол Улсын Гавьяат жужигчин Х.Төмөрбаатарын нэрэмжит “Эстрадын дуу дуулаачид” аймгийн уралдааныг 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсугай.

Хоёр. Дээрх уралдааны шагналд шаардагдах 500000 /Таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

023000492